



Save the
Children

2024 ОНЫ 7 ДУГААР САР

ЦАХИМ СОНИН

“СУРГУУЛЬТАЙ ХАМТРАН ХҮҮХЭД ХАМГААЛЛЫГ САЙЖРУУЛАХ НЬ” ТӨСӨЛ

Сайн байцгаана уу?


Хүүхдийг Ивээх Сан “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийг Хүүхдийг Ивээх Сангийн Олон Улсын Эвслийн санхүүжилтээр Улаанбаатар хот, Говь-Алтай, Ховд аймагт 2023-2025 онд хэрэгжүүлж байна. Хүүхэд хамгааллын энэхүү цогц төсөлд Улаанбаатар хотын Хан-Уул, Баянгол, Чингэлтэй, Сүхбаатар, Баянзүрх дүүрэг болон Говь-Алтай, Ховд аймгийн нийт 14 сургууль, 14 хамтарсан баг хамрагдаж байгаа билээ. Бид төслийн үйл ажиллагаа, үр дүн болон бусад мэдээллийг шуурхай, цогц байдлаар хүргэх зорилгоор сар тутам “Цахим сонин” гарган та бүхэндээ хүргэхээр боллоо. Анхны дугаарыг хүлээн авна уу.

Хүүхдийг Ивээх Сангийн Хүүхэд хамгаалал, Хүүхдийн эрхийн засаглалын хөтөлбөрүүдийн менежер Э.Цолмон



2023 ОНЫ ГОЛ ҮЙЛ АЖИЛЛАГАА

- Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь төслийн санамж бичгийг ХНХЯ, БШУЯ болон Ховд, Говь-Алтай аймгуудын Засаг даргын Тамгын газартай тус тус үзэглэн төслийн үйл ажиллагаа эхлэв.
- ХИС-ийн Олон улсын эвслийн арга зүйг түгээн дэлгэрүүлэх ажлын хүрээнд сурагчдын сурч хөгжих үйл явцыг эрхэдсуурилсан хандлагаар дэмжих нь сургалтын сургагч багшаар төслийн 14 сургуулийн ажлын хэсгийн багш нарыг сургасан байна.
- “Хүүхдийг хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, мэдээлэх, хариу арга хэмжээ авах арга зүй” сургалтад төслийн 14 сургуулийн ажлын хэсгийн багш нар болон 14 хамтарсан багийн гишүүдийг ХИС-ийн Олон улсын эвслийн арга зүйг түгээн дэлгэрүүлэх ажлын хүрээнд сургав.
- Сайн эцэг эх сургалтын сургагч багшаар 14 сургуулийн 150 гаруй сургагч багш бэлтгэлээ.
- Сайн эцэг эх сургалтад төслийн 14 сургуулийн 784 эцэг эх, асран хамгаалагчийг сургалаа.
- “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төсөл хэрэгжүүлж буй Улаанбаатар хотын 10 сургуулийн төлөөлөл Ховд аймгийн Жаргалант сумын 1-р сургууль, Дарви сумын дунд сургууль, Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын 4-р сургууль, Дарив сумын дунд сургуулиудаар зочилж, сургуулиудын баг хамт олонтой сургуулийн орчны хүүхэд хамгааллыг сайжруулах болон удирдлага менежментийн чиглэлээр харилцан туршлагаа солилцов.



11 329365



mongolia.secretary@savethechildren.org



Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Аризона төв, 4 давхар

“СУРГУУЛЬТАЙ ХАМТРАН ХҮҮХЭД ХАМГААЛЛЫГ САЙЖРУУЛАХ НЬ” ТӨСӨЛ

2024 ОНЫ ГОЛ ҮЙЛ АЖИЛЛАГАА

- Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь төслийн хүрээнд Говь-Алтай, Ховд аймаг болон Улаанбаатар хотын, 14 сургуулийн ажлын хэсгийн гишүүдийг “Би найзаа дэмжинэ” олон улсын хөтөлбөрийн сургалтын чиглүүлэгчээр 140 багш бэлтгэлээ.
- Төслийн 14 сургууль, 14 хорооны хамтарсан багтай ажиллах гэрээ байгуулав.
- Төслийн хүрээнд Говь-Алтай, Ховд аймгийн хамтарсан багийнханд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзээлэхэд шаардлагатай эд зүйлсийн дэмжлэгийг Хүүхдийг Ивээх Сангаас үзүүлэв.
- “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийн багийнхан нийслэлийн зорилтот 5 дүүргийн 10 хорооны Засаг дарга болон хамтарсан багийнхантай уулзалт хийж, төслийн хэрэгжилтийг танилцуулан, хүүхэд хамгааллын мэргэжилтнүүдэд зориулсан “Даван туулагч” баримтат уран сайхны киног үзүүлж, хүүхэд хамгааллын үйлчилгээний зарим хэрэглэгдэхүүний багц бүхий цүнх гардуулж өглөө.
- ХИС-ийн Олон улсын эвслийн арга зүйг түгээн дэлгэрүүлэх ажлын хүрээнд “Хүүхдийг хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, мэдээлэх, хариу арга хэмжээ авах арга зүй” сургалтад хамрагдсан чиглүүлэгч багш нар сургууль тус бүрдээ 50 багш, 56 эцэг эхийг сургав.
- Төслийн ерөнхий боловсролын сургуулийн хүүхэд хамгааллын баг, хорооны хамтарсан багууд хамтран ажиллах гэрээ байгуулж, хамтран ажиллах төлөвлөгөөг гарган хэрэгжүүлэн ажиллаж байна.
- Ховд, Говь-Алтай, аймгийн ерөнхий боловсролын сургуулиудын үр дүнгийн уулзалт болж аймгийн ЗДТГ, Боловсрол, соёлын газар болон Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын төлөөллүүд, Улаанбаатар хотын Баянгол дүүргийн ЕБ-ын 51, 73-р сургуулиудын үр дүнгийн хурал болж, дүүргийн Боловсролын хэлтэс, Нийгмийн бодлогын хэлтийн төлөөллүүд оролцов.
- Хүүхдийг Ивээх Сангийн Хүүхэд хамгааллын хөтөлбөрөөс хүүхэд хамгааллын хариу үйлчилгээнд сэтгэцийн гэмтэлд суурилсан, хохирогч/даван туулагчдад ээлтэй арга зүйг түгээхээр Ховд, Говь-Алтай аймгийн бүх хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах сургалт зохион байгуулав.
- Төслийн хүрээнд 1850 хүүхдийг “Би найзаа дэмжинэ” сургалтын хүрээнд үе тэнгийн дэмжигч хүүхдээр бэлтгэлээ.
- Улаанбаатар хотын 10 сургууль, 10 хорооны хамтарсан багийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нарын дунд кейс хэлэлцүүлэг амжилттай зохион байгууллаа.
- Төслийн ерөнхий боловсролын сургуулиудын эцэг эхийн зөвлөлийн 800 гаруй төлөөлөлтэй уулзалт хийж, эцэг эхийн үйл ажиллагааны хөтөлбөр, сургалтын мэдээлэл өглөө.

Нийслэлийн Баянзүрх дүүргийн 3-р хорооны нийгмийн ажилтан

Ц.Ариундарь: Энэ цүнхэнд хэрэгцээ шаардлагатай зүйлүүд олон байна

“Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслөөс нийслэлийн зорилтот 5 дүүргийн 10 хорооны Засаг дарга болон хамтарсан багийнханд төслийн хэрэгжилтийг танилцуулан, хүүхэд хамгааллын мэргэжилтнүүдэд зориулсан “Даван туулагч” баримтат уран сайхны киног үзүүлж, хүүхэд хамгааллын үйлчилгээний зарим хэрэглэгдэхүүний багц гардуулж өглөө. Нийслэлийн Баянзүрх дүүргийн 3-р хорооны нийгмийн ажилтан Ц.Ариундарь: Энэ цүнхэнд хэрэгцээ шаардлагатай зүйлүүд олон байна. Жишээ нь, дуу хураагуур байлаа. Гэр бүлд нөхцөл байдлын үнэлгээ хийхэд хамгийн их хэрэгцээтэй байдаг. Тухайн үйлчлүүлэгчээс зөвшөөрлийг авсны дагуу яриаг хурааж, улмаар үнэлгээг бүрэн бөглөхөд чухал дэмжлэг гэж харж байна. Эко зураглал, генограмм зурах шугамыг хүртэл өгсөнд талархаж байна. Мөн гэрэлтүүлэг багатай үед гэр бүлд нөхцөл байдлын үнэлгээ хийхээр очих тохиолдол их гардаг. Энэ үед гар чийдэн хэрэгтэй.



“СУРГУУЛЬТАЙ ХАМТРАН ХҮҮХЭД ХАМГААЛЛЫГ САЙЖРУУЛАХ НЬ” ТӨСӨЛ**АМЖИЛТЫН ТҮҮХ****Б.БҮТЭНЖАРГАЛ: ХҮҮХЭД БАЙГАА ГАЗАР ХАМГААЛАЛ БАЙХ ЁСТОЙ, ХҮН БҮР ХҮҮХДЭЭ ХАМГААЛАХ ҮҮРЭГТЭЙ ГЭДГЭЭ ОЙЛГОХ НЬ ЧУХАЛ**

Говь-Алтай аймгийн Дарив сум нийслэл Улаанбаатар хотоос 1200 км, аймгийнхаа төвөөс 200 км зайтай байрладаг. Баруун бүсийг нийслэлтэй холбосон сайжруулсан засмал замаас 50 км шороон замаар явж очих боломжтой. Эргэн тойрондоо өндөр уулсаар хүрээлэгдсэн, том нуурын эрэгт оршдог. Өвөлдөө хүйтэн, зундаа халуун уур амьсгалтай. Говь-Алтай аймгийн Дарив сум нь 1700 гаруй хүн амтай. Хүн амын ихэнх нь мал аж ахуй эрхэлдэг.

Говь-Алтай аймгийн Дарив сумын Ерөнхий боловсролын сургуулийн Нийгэм, иргэний ёс зүйн боловсролын багш Б.Бүтэнжаргал сургуульдаа 5 дахь жилдээ багшилж байна. Тэрээр МУБИС-ийг Нийгэм судлалын багш мэргэжлээр 2019 онд төгссөн. Иргэний ёс зүйн боловсрол хичээл, Нийгэм судлалын хичээлийг 7, 8, 10 дугаар ангиудад заадаг.

Түүний хувьд арга зүй, ур чадвараа нэмэгдүүлэх, туршлага хуримтлуулах зорилгоор “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийн сургагч багш болжээ. Б.Бүтэнжаргал “Төсөлд хамрагдаад, сургалтад сууж, олон зүйлийг сурч мэдсэн байгаа. Тухайлбал, хүүхдийг хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг аль болох эрт илрүүлэх шаардлагатай юм байналаа. Илрүүлсэн тохиолдолд ямар хариу арга хэмжээ авах гэх мэтийн арга зүй, ур чадварт суралцсан. Багш хүн сурагчдаа ажиглах, харилцан ярилцах нь хүртэл эрт илрүүлэгт чухал юм билээ. Багш хүн өөрөө энэ бүхнийг мэдээд авахаар санаатай болон санамсаргүй байдлаар ч хүүхэдтэй ямарваа байдлаар зүй зохисгүй харьцахгүй зан төлөвт суралцаж байна” хэмээн ярилаа.

Тэрээр сургагч багш болсны дараа сургуулийнхаа 50 багш, ажилтнуудад сургалт явуулсан байна. Мөн хэрхэн сайн эцэг, эх байх талаар сургалт зохион байгуулжээ. Эцэг эхчүүд, асран хамгаалагчид, багш нар дотор үеийн ялгаа бий, тэд хүүхдийн хүмүүжил, сурч хөгжих үйл явцыг дэмжих өөр өөр туршлагатай. Зарим үед хүүхэдтэйгээ хэрхэн харьцахаа мэдэхгүйд хүрч барьц алдах үе хэн хэнд нь л тулгарч байна. Яагаад ийм асуудал тулгарч байгаа билээ, ямар гаргалгаа байна вэ гэдгийг ойлгосон оролцогчид сургалтыг тун эергээр хүлээн авч, нэлээд сэтгэл ханамжтай байсан. Хүүхэд байгаа газар хамгаалал байх ёстой, хүн бүр хүүхдээ хамгаалах үүрэгтэй гэдгийг ойлгож байгаа нь чухал.

Сургалтын хөтөлбөр нь тэдний амьдралд нэн хэрэгцээтэй байсан талаар Б.Бүтэнжаргал ярьж байна. Сургалтад хамрагдаагүй олон эцэг, эхчүүд энэ сургалтад хамруулж өгөөч, бид оролцмоор байна гэсэн хүсэлт гаргаж байв. Хандлага өөрчлөхөд цаг хугацаа хэрэгтэй учраас сургалтад илүү олон хүн хамруулах шаардлагатай хэмээн боддог талаараа ярилаа. Дарив сумын сургуулийн нэг онцлог нь малчдын хүүхдүүдийн ихэнх нь дотуур байранд амьдардаг.



Сургууль нийт 350 хүүхэдтэй бөгөөд 80 орчим нь дотуур байранд амьдардаг байна. Тэдний хувьд эцэг, эхээсээ хол бие даан амьдрах, нийгмийн харилцаанд оролцох хэрэгцээ шаардлага тулгардаг. Үүний тулд бүх орчинд тэдгээр хүүхдүүдэд хамгаалал чухал байдаг.

Малчдын хүүхдүүд амралтын өдрөөрөө гэртээ очих хүсэлтэй байдаг ч заримд нь боломж байхгүй. Энэ сум өндөр уулсаар хүрээлэгдсэн учраас өвлийн улиралд цас их орж, автомашины зам олонтаа хаагддаг. Тиймээс малчдын хүүхдүүд гэртээ очоод сургуульдаа буцаж ирж чадахгүй хүлээх тохиолдол нэлээд гардаг байна.

Сумын Засаг даргын Тамгын газраас “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийн ажлыг дэмжин, эрсдэлийн үнэлгээ дээр суурилан сургуулийн орчинд хяналтын камер суурилуулах ажил хийсэн байна.

Дарив сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал Х.Нямдаваа “Б.Бүтэнжаргал ажлын хэсэгт орсноор багийнхаа уриалж, итгэл зүтгэлтэй ажиллаж байна. Түүний хувьд төслийн сургалт явуулах техник туслалца үзүүлэх, сургалтын орчин нөхцөлөө бэлтгэн бүрдүүлэх, тайлагнах ажлыг хариуцаж, цаг хугацаанд нь чанартай гүйцэтгэж байгаа. Манай сургуулийн зүгээс залуу багш нараа дэмжих, төсөл хөтөлбөрт хамруулах чиглэлээр ажилладаг. Тиймээс төслийн ажлын хэсгийг голдуу залуу багш нараар бүрдүүлж, тэднийг сургалтад хамруулан мэдлэг, чадвараа нэмэгдүүлэхийг дэмжиж байна. Залуу багш нар ажлын ачаалал даах, сурсан зүйлсээ хэрэгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх, хүүхдүүдэд нөлөөлөх тал дээр илүү сайжирч ажиллаж байгаа” хэмээн ярилаа.

“СУРГУУЛЬТАЙ ХАМТРАН ХҮҮХЭД ХАМГААЛЛЫГ САЙЖРУУЛАХ НЬ” ТӨСӨЛ

МЭДЭЭ, МЭДЭЭЛЛҮҮД



“Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төсөлд хамрагдаж буй 14 сургуулийн захирлуудын зөвлөлдөх уулзалтыг 4-р сарын 24-ний өдөр цахим болон танхимын хосолсон хэлбэрээр зохион байгууллаа.



“Сайн эцэг эх” сургалтыг түгээн дэлгэрүүлэх хүрээнд: Улаанбаатар хотын 10 сургуульд нийт 6826 эцэг эх, Ховд аймгийн 2 сургууль 995, Говь-Алтай аймгийн 2 сургууль 918 эцэг эхийг тус сургалтад хамруулаад байна.



“Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийг нийслэлд хэрэгжүүлж байгаа БГД, БЗД, СБД, ХУД, ЧД-ийн ерөнхий боловсролын сургуулиудын нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, хорооны нийгмийн ажилтан нарын дунд улирал тутам зохион байгуулах “Кейс хэлэлцүүлэг”-ийг амжилттай зохион байгууллаа.



“Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийн Улаанбаатар хотын ерөнхий боловсролын сургуулиудын сэтгэл зүйч нарын туршлага солилцох уулзалт 2024 оны 5-р сарын 22-нд зохион байгууллаа.



Хагас жилийн дүгнэлт уулзалтыг Улаанбаатар хотын 33, 48, 50, 51 болон 73, 2, 17, 58, 75, 130 сургуулийн 493 багш ажилтнуудыг хамруулан зохион байгуулсан. Мөн Ховд аймгийн Дарви сумын 62 багш ажилтнуудыг оролцуулан зохион байгууллаа.

ИРЭХ САРУУДАД БОЛОХ ҮЙЛ АЖИЛЛАГААНУУД

9-Р САР

- “Хүнлэг байя” нөлөөллийн ажлыг Улаанбаатар, Говь-Алтай, Ховд аймгийн 14 сургууль болон орон даяар нээх
- Ерөнхий боловсролын сургуулиудын нийгмийн ажилтан сэтгэл зүйч, хороодын нийгмийн ажилтнуудын дунд кейс хэлэлцүүлэг зохион байгуулах
- Хүүхдийн оролцоо, Хүүхдийн эрхийн зөрчил гарахад хэнд, хаана хэрхэн хандах вэ? гарын авлагын танилцуулах сургалтууд зохион байгуулах

10-Р САР

- “Хүнлэг байя” нөлөөллийн үйл ажиллагаа үргэлжлэх
- Эцэг эхийн санаачлан хэрэгжүүлэх үйл ажиллагаа эхлэх
- Хүүхдийн санаачлан хийх 42 үйл ажиллагаа эхлэх

11-Р САР

- Хүүхдийн санаачлан хийсэн 42-р үйл ажиллагааны тайлан
- Төслийн үйл ажиллагааны хяналт үнэлгээ хийх
- “Хүнлэг байя” нөлөөллийн үйл ажиллагааны үр дүнг үнэлэх судалгаа